



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/521

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд жишиг хоршоо хөгжүүлэх, арьс, ширэнд анхан шатны тордолт хийх, малын тэжээл үйлдвэрлэх, мал тэжээх арга туршлагын талаарх сургалтуудыг 2021 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 18-ны өдрүүдэд сумдад зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө хүргэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 2,111,900 (хоёр сая нэг зуун арван нэгэн мянга есөн зуу) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101104

Аймгийн Засаг даргын 10 оны  
25 дугаар сарын 10-ний өдрийн  
захирамжийн хавсралт

Хөдөө аж ахуйн салбарын зөвлөх мэргэжилтнүүдийн сумдад ажиллах  
зардлын жагсаалт

№	Сумдын нэрс	Сумдад ажиллах зөвлөх мэргэжилтний тоо	Нийт км	Шатахуун /литр/	Шатахууны үнэ /төг/	Томилолт /төг/	Бүгд /төг/
1	Уянга, Тарагт	3	140	28	60200	159000	219200
2	Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт, Хархорин	2	380	76	163400	212000	375400
3	Сант, Баянгол, Төгрөг, Гучин-Ус	3	370	74	159100	318000	477100
4	Богд, Баруунбаян- Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан	3	575	115	247250	318000	565250
5	Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Баян-Өндөр	3	365	73	156950	318000	474950
	Нийт		1830	366	786900	1325000	2111900

-оОо-